



ЦУС СЭЛБЭЛТ СУДАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ


Ж – EP - 2- 20 -03

**ТӨВИЙН ЦАХИМ ХУУДАС, “MGL Blood Donor App”
АППЛИКЕЙШНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

ЭХ ХУВЬ 1

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 1/ 11

Боловсруулсан:	Хянан засварласан	Хянасан:	Баталсан:
ЭШМТА-ны мэдээллийн технологийн инженер	ЭШМТА-ны дарга	ЦЧАБ-ийн албаны дарга	ЦССҮТ –ийн захирал
Ч.Далайцэрэн	Н.Янжиндулам	Т.Алимаа	Н.Эрдэнэбаяр
Огноо: 2021.07.01	Огноо: 2021.08.26	Огноо: 2021.08.27	Огноо: 2021.08.27
Гарын үсэг	Гарын үсэг	Гарын үсэг	Гарын үсэг



Төлөөлөгч	Албан тушаал	Гарын үсэг
	ЭШМТА	<i>[Signature]</i>
	ЦЧАБ/Иба	А. Амаржаргал
Хуучинтай хугацаа	20 27 он 08 сар 27 өдөр	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба		Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон "MGL Blood Donor App" аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам	
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 2/ 11	

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д. д	Хуудас №	Бүлэг №	Өөрчлөлт оруулсан огноо	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	ЧАД-н гарын үсэг	Даргын гарын үсэг
1	1	-	2021.05.27	Журмын нэр сольсон	Сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах		
2	2	-	2021.05.27	Журам Хянан засварлах албан тушаалтны мэдээлэл оруулсан	Журам хянасан албан тушаалтан солигдсон		
3	5	-	2021.05.27	Цахим хуудас болон "MGL Blood Donor App" аппликейшиныг ажиллуулах болгон өөрчилсөн	болон "MGL Blood Donor App" аппликейшины үйл ажиллагааг журамлах		
4	5	-	2021.05.27	Эрх үүргийн утга, агуулга өөрчлсөн	Эрх үүргийг тодорхой болгох		
5	7	2	2021.05.27	Журмаар зохицуулах ажиллагааг шинэчилсэн үйл	Журмаар зохицуулах үйл ажиллагааг тодорхой болгох		
6	9	5	2021.05.27	Мэдээлэл байршуулагчийн ҮЯТ нэмсэн	Мэдээлэл байршуулах үйл явцыг тодорхой болгох		
7	5-9	1-5	2021.08.26	Хавсралтаар мэдээ, мэдээлэл байршуулах ҮЯТ-ыг нэмсэн	УЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн санал		
8	5-9	1-5	2021.08.27	Аппликейшний нэрийг өөрчилсөн	Аппликейшний нэр өөрчлөгдсөн		

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон "MGL Blood Donor App" аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 3/ 11

Агуулга

Д/д	Бүлэг	Хуудас №
	Өөрчлөлт оруулсан бүртгэл	
1.	Тодорхойлолт, товчилсон үг	5
2.	Зорилго	5
3.	Хамрах хүрээ	5
4.	Журмаар зохицуулах үйл ажиллагаа	
5.	Үүрэг хариуцлага	6
6.	Лавлах материал	8
7.	Хавсралт	9-10
8.	Холбогдох баримт бичиг	11

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба			
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам	
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.
		Хуудас 4/ 11	

1. Тодорхойлт, товчилсон үг:

1.1 Тодорхойлолт: Дор дурдсан нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

- 1.1.1 **Хэрэглэгч:** Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшин ашиглагч
- 1.1.2 **Ерөнхий админ:** Техник хариуцсан Мэдээллийн технологийн инженер
- 1.1.3 **Мэдээний админ:** Захиргаа маркетингийн албаны дарга
- 1.1.4 **Засварлагч:** Программ хангамж болон сүлжээ хариуцсан мэдээллийн технологийн инженер
- 1.1.5 **Мэдээ байршуулагч:** Маркетинг олон нийттэй харилцах ажилтан, Маркетинг нийгмийн эрүүл мэндийн ажилтан нар
- 1.1.6 **Эх сурвалж бэлтгэгч:** Мэдээ, мэдээллийн эхийг хариуцагч (Төвийн ажилтан, албаны дарга, тасгийн эрхлэгч гэх мэт тухайн мэдээ, мэдээллийн агуулгыг бэлтгэсэн ажилтан)

1.2 Товчилсон үг:

- ЦССҮТ- Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв
- ЭШМТА- Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба
- ЦЧАБА- Цусны чанар, аюулгүй байдлын алба
- САЗ- Стандарт ажиллагааны заавар
- ТТАЗ- Тоног төхөөрөмж ажиллуулах заавар
- Ж- журам
- ДЭМБ – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

2. **Зорилго:** Төвийн цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний тасралтгүй ажиллагаа, хөгжүүлэлтийг хангах зорилгоор шинэчлэл хийх, мэдээ, мэдээлэл байршуулах, засах, хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

3. **Хамрах хүрээ:** Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн (ЦССҮТ-ийн) бүх алба, тасгийн эмч, мэргэжилтэн, ажиллагсад мөрдөнө.

4. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

4.1 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний зохион байгуулалт, дизайн, агуулга, түүнд тусгах мэдээ, мэдээллийг засварлах болон шинэчлэх, тэдгээрийг бэлтгэх, хянах үйл ажиллагаанд оролцогчид, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлох үйл ажиллагааг зохицуулна.

4.2 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний мэдээллийг засварлах болон шинэчлэх

4.2.1 Засварлагч цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний үндсэн болон дэд цэсэнд холбогдох мэдээллийг хариуцсан албаны дарга, тасгийн эрхлэгч нарын бэлтгэсний дагуу оруулах

4.2.2 Дээрхээс бусад ажилтан мэдээллийг бэлтгэсэн бол хариуцсан албаны дарга, тасгийн эрхлэгч нар хянаж, зөвшөөрсөний дараа оруулах

4.3 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшинд мэдээ байршуулах

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 5/ 11

- 4.3.1 Мэдээ байршуулагч мэдээний эхийг эх сурвалжаас /хариуцсан алба, тасаг, ажилтан/ авч, агуулгыг боловсруулан Мэдээний админаар хянуулан, байршуулах
- 4.3.2 Төвийн гаднах харилцагчаас эх сурвалжтай мэдээг тухайн хариуцагчтай хамтран боловсруулан Мэдээний админаар хянуулан, байршуулах
- 4.4 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний мэдээ, мэдээллийг залруулах, нөөцлөх
 - 4.4.1 Алдаатай, ташаа мэдээ, мэдээллийг илэрсэн даруйд залруулах арга хэмжээг Ерөнхий админ хариуцаж, Засварлагч болон Мэдээ байршуулагч нараар гүйцэтгүүлэх, шаардлагатай (засварлагч болон мэдээ байршуулагч нарын эзгүйд) тохиолдолд өөрөө гүйцэтгэх
 - 4.4.2 Ерөнхий админ цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшний мэдээллийг сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр нөөцлөх
 - 4.4.3 Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшинд мэдээлэл байршуулсан, баяжилт болон өөрчлөлт хийсэн тухай харьяалагдах алба, тасгийн эрхлэгчид улирал тутам танилцуулах үүрэгтэй

5. Үүрэг хариуцлага

5.1 Төвийн ерөнхий захирлын эрх, үүрэг

- 5.1.1 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшнийг ажиллуулах техник, тоног төхөөрөмжийн нөхцөлөөр хангах үүрэгтэй
- 5.1.2 Админууд, засварлагч, мэдээ байршуулагч нарыг томилох, тэдэнд эрх олгох, түдгэлзүүлэх эрхтэй
- 5.1.3 Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний зохион байгуулалт, дизайн, агуулгыг тодорхойлох, өөрчлөх шийдвэр гаргах эрхтэй.
- 5.1.4 Програмын хангамжийг өргөтгөх, техникийн шийдлийг сайжруулах зорилгоор холбогдох этгээдтэй хамтран ажиллах эрхтэй.

5.2 Алба, тасгийн дарга, эрхлэгчийн эрх, үүрэг

- 5.2.1 Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний ашиглалтыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх санал танилцуулах үүрэгтэй.
- 5.2.2 Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний зохион байгуулалт, дизайн, агуулгыг тодорхойлох, өөрчлөхөд санал өгөх, түүнд оруулах мэдээ, мэдээллийг хянах, нийтлэх, засварлах, шинэчлэх шийдвэр гаргах эрхтэй.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 6/ 11

5.2.3 Програм хангамжийг сайжруулах, техникийн шийдлийг сайжруулах зорилгоор хамтран ажиллаж байгаа этгээдэд саналаа өгөх, шийдвэрлүүлэх эрхтэй.

5.2.4 Админ, засварлагч, мэдээ байршуулагч нарын хянуулахаар өгсөн болон байршуулсан мэдээ, мэдээлэлд хяналт тавих эрхтэй

5.3 Админы эрх, үүрэг

5.3.1 Ерөнхий болон Мэдээний админууд цахим хуудас, “MGL Blood Donor App”аппликейшний тасралтгүй үйл ажиллагааг хариуцах, хянах үүрэгтэй

5.3.2 Ерөнхий админ мэдээ, мэдээлэл засварлах, байршуулах зэрэг үйлдлийг шаардлагатай (засварлагч болон мэдээ байршуулагч нарын эзгүйд) тохиолдолд хийх эрхтэй

5.3.3 Ерөнхий админ засварлагчийн эзгүйд эрх үүргийг шилжүүлэн хэрэгжүүлэх

5.3.4 Ерөнхий админ засварлагч, мэдээ байршуулагч нарт хандах (зөвхөн мэдээ байршуулах болон засварлах) эрх олгох, тэдний эрхийг түдгэлзүүлэх эрхтэй

5.3.5 Ерөнхий админ цахим хуудас, “MGL Blood Donor App”аппликейшний дизайны шийдэл, ерөнхий үйл ажиллагааг зохион байгуулах болон техникийн бусад асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй

5.3.6 Засварлагч, мэдээ байршуулагч нарыг сургах, заавар зөвлөгөө өгөх үүрэгтэй

5.4 Засварлагчийн эрх, үүрэг

5.4.1 Ерөнхий админаас өгсөн чиглэлийн дагуу Цахим хуудас, “MGL Blood Donor App”аппликейшнийг засварын горимоор нээх, өөрчлөлт, баяжилт хийх, шинэ мэдээлэл байршуулах тусгай эрхтэй

5.4.2 Цахим хуудас, “MGL Blood Donor App”аппликейшний дизайн болон ерөнхий үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ерөнхий админд санал тавих эрхтэй

5.4.3 Хандах эрх авснаас хойш ажлын тав хоногийн дотор ерөнхий админ аас сургалт, зөвлөгөө авах үүрэгтэй

5.4.4 Шаардлага хангаагүй, хянагдаагүй /Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаал, “Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журам”-ын 6.3 дахь заалтыг зөрчсөн/ мэдээллийг байршуулахаас сэргийлэх эрхтэй

5.4.5 Шаардлагатай (мэдээ байршуулагч, ерөнхий админий эзгүйд) үед мэдээ, мэдээлэл байршуулах үүрэгтэй

5.4.6 Хандах эрхийг ерөнхий админий зөвшөөрөлгүйгээр шилжүүлэхгүй байх

5.4.7 Үүрэгт ажлаас түр хугацаагаар болон бүрэн чөлөөлөгдсөн тохиолдолд тусгай эрхээ хаалгуулах үүрэгтэй

5.4. Мэдээ байршуулагчийн эрх, үүрэг

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App”аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 7/ 11

- 5.4.1 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшинд цаг үеийн үйл явдалтай холбоотой мэдээг байршуулах үүрэгтэй
- 5.4.2 Мэдээг утга найруулга, дүрмийн алдаагүй, хуулийн хүрээнд бэлтгэн Мэдээний админаар хянуулах үүрэгтэй
- 5.4.3 Мэдээний эхийг Төвийн удирдлага, мэдээний админы өгсөн чиглэлийн дагуу хариуцах ажилтнаас шаардах эрхтэй
- 5.4.4 Цахим хуудас, “MGL Blood Donor App” аппликейшинд шаардлага хангаагүй /ЭМ-ийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаал, “Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журам”-ын 6.3 дахь заалтыг зөрчсөн/ мэдээг хүлээн авахаас татгалзах эрхтэй
- 5.4.5 Хандах эрхийг ерөнхий админий зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй байх
- 5.4.6 Үүрэгт ажлаас түр хугацаагаар болон бүрэн чөлөөлөгдсөн тохиолдолд тусгай эрхээ хаалгуулах
- 5.4.7 Мэдээний бичвэрийг UNICODE –оор бичих

5.5 Мэдээ, мэдээллийн эх сурвалж бэлтгэгчийн эрх, үүрэг

- 5.5.1 Мэдээний эх сурвалж бэлтгэгч тухайн үйл явдал, арга хэмжээний талаар үндсэн агуулгыг /юу, хэзээ, хаана, ямар зорилгоор, хэрхэн болсон, ямар ач холбогдолтой, үр дүнтэй болсон болон оролцогч талууд, зохион байгуулагч талууд, хамрах хүрээ зэрэг/ тухай бүр шуурхай бэлтгэж, мэдээ байршуулагчид өгөх үүрэгтэй
- 5.5.2 Мэдээний үндсэн агуулгыг үнэн зөв, ашиг сонирхолоос ангид байх зарчимаар бэлтгэх үүрэгтэй
- 5.5.3 Гадны эх сурвалжтай мэдээг тухайн хариуцагчаас хүсэх эрхтэй
- 5.5.4 Мэдээллийн эх сурвалж бэлтгэгч тухайн цэсэнд холбогдох мэдээллийг өөрчлөх шаардлага гарсан тохиолдол /тушаал, шийдвэр өөрчлөгдөх, шинэ журам, мэдээлэл нэмэгдэх, зар хүргэх зэрэг/ бүрт боловсруулах үүрэгтэй
- 5.5.5 Боловсруулсан мэдээллийг хариуцсан албаны дарга, тасгийн эрхлэгч нараар хянуулж, засварлагчид өгөх үүрэгтэй
- 5.5.6 Мэдээллийг баталгаажуулахыг хариуцсан албаны дарга, тасгийн эрхлэгч нараас хүсэх эрхтэй


6. Лавлах материал

- 6.1 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаал
- 6.2 Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хийсэн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан 2020
- 6.3 Цусны албаны мэдээлэл технологийн хөгжлийн бодлого 2019-2025 он

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 8/ 11


7. Хавсралт

Мэдээ байршуулах үйл явцийн тодорхойлолт



Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” апликаейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 9/ 11

Мэдээлэл байршуулах үйл явцийн тодорхойлолт



Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон "MGL Blood Donor App" аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 10/ 11

8. Холбогдох баримт бичиг

8.1 Цусны албаны мэдээллийн аюулгүй байдлын журам

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн № Ж – EP - 2- 20 -03		Цахим хуудас болон “MGL Blood Donor App” аппликейшний байнгын үйл ажиллагааг хангах журам		
Хэвлэлт №02	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.07.20	Өөрчлөлт 2	Өөрчлөлт оруулсан огноо: 2021.08.27.	Хуудас 11/ 11

